

**ШУУРХАЙ ХЯНАЛТЫН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ЦОГТСАЙХАН ОВОГТОЙ ХАТАНБОЛДЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин /Эхний хагас жил/	Хүрсэн түвшин (биелэлт)			
			3	4	5			
1	2	3	4	5	6	7		
Зорилт 1. “УЛСЫН ХИЛЭЭР ХУУЛЬ БУСААР БАРАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ НЭВТРҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ”								
1.	Теле хяналтын нэгдсэн систем, камерын хэвийн, найдвартай, аюулгүй байдлыг ханган ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ГЕГ-т бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа нийт 164 гаалийн хяналтын бүс байгаагаас өнөөдрийн байдлаар нийт 145 гаалийн хяналтын бүсийн тухайн аж, ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар суурилуулсан 1520 хяналтын камерыг ГЕГ-ын телехяналтын нэгдсэн системд холбож, хяналтын нэгдсэн төвөөс хяналт тавих, холбогдох нэгжүүдийг мэдээллээр хангах нөхцөл бололцоо бүрдсэн.	Харьяа гаалийн газар, хороод, гаалийн хяналтын бүсүүдэд ашиглагдаж буй дэд систем, хяналтын камер бусад тоног төхөөрөмжийн тоо бүртгэл, графикт үзлэг үйлчилгээ, ашиглалтад хяналт тавих, хэвийн тасралтгүй ажиллагааг хангах чиглэлээр ажил зохион байгуулсан байна. Тоног төхөөрөмжийн судалгаа хийж, шаардлагатай шинэчлэлтийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	ТХНС, дагалдах тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллааг хангах чиглэлээр: -Дэд системийн хэвийн найдвартай ажиллагаа, арчилгаа үйлчилгээ, ашиглалтын чиглэлээр дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах чиглэлийг 2 удаагийн албан бичгээр харьяа ГГХ-д хүргүүлсэн. -Нийт 118 удаагийн заавар зөвлөгөөг утсаар цахимаар өгч, цаг тухайд нь тоног төхөөрөмж болон сүлжээнд тохиргоог хийж ажилласан. Дэд системд нэвтрэн хяналт тавих ажлын байр тус бүрээр эрхийг нээж өгсөн. -ГГХ-оос ирүүлсэн гэмтэлтэй, засварлуулах шаардлагатай телекамер болон бусад дагалдах тоног төхөөрөмжийн бүртгэлийг тухай бүрт нь хөтлөн, шаардлагатай засвар үйлчилгээний талаар удирдлагад танилцуулан, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж, 2019 онд “Ай Ти Зон” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2024.01.02-ны өдрийн байдлаар эвдрэл, гэмтэлтэй, засварлуулах шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн судалгааг гарган, баталгаат засварын хугацаанд засварлуулахаар жагсаалтыг 2024.01.16-ны өдөр “Ай Ти Зон” ХХК-д хүргүүлсэн. Ай Ти Зон ХХК-аас эдгээр тоног	2024.01.01-2024.06.10		

				<p>төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах тухай хариу мэдэгдсэн.</p> <p>-ГСГГ, Ханги дахь ГГ, УХШИГГ-т шинээр ГХБ-ээр зарлуулах хүсэлт ирүүлсэн 7 ААН-н телекамерын байршил, тоо ширхэг, бичлэг хадгалах хугацаа журмын шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, ТХНС-д холбож, телехяналт тавих нөхцөл бололцоог хангаж ажилласан.</p> <p>Телехяналтын камер, дагалдах тоног төхөөрөмжийн судалгааны чиглэлээр:</p> <p>- Боомтын шинэчлэлийн хүрээнд БНХАУ-ын буцалтгүй тусламжаар бүтээн байгуулалт хийгдэж буй ЗҮГГ-ын газрын ачаа тээврийн цогцолборт, ГСГГ-ын хяналтын бүсүүдэд, Шинээр төлөвлөгдөж буй Цагаандэл Уул боомтод, RIBS төслийн хүрээнд бүтээн байгуулалт хийгдэхээр төлөвлөгдөж буй Хавирга, Цагааннуур, Булган боомтод, ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвд тус тус суурилуулах телекамерын байршил, тоо ширхэг болон дагалдах тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийн судалгааг гарган, жагсаалтыг холбогдох нэгжүүд болон Сангийн яам, тендерийн ҮХ-нд хүргүүлсэн.</p> <p>-МУЗГ-ын "Гаалийн шинэчлэл"-ийн хүрээнд Боршоо, Сүхбаатар боомтын телехяналтын системийг хүлээн авч, ТХНС-д бүрэн холбосон.</p> <p>-Дэд системүүдийн бичлэг хадгалах хугацааг уртасгах зорилгоор нэмэлт хард зайлшгүй шаардлагатай байгааг СХОГ-аар шийдвэрлүүлэн, ЧХОУНБГГ-т 12ш, ЗҮГГ-т 12ш, УБГГ-т 6ш нэмэлтээр суурилуулсан.</p> <p>- Ханги ГГ-ын GENETEC лиценз шинэчлэн, ТХНС-д холбосон.</p> <p>-ЗҮГГ-1, УХШИГГ-2, Боршоо-2 рентген ТХНС-д холбож, телехяналт тавих нөхцөл боломжийг хангасан.</p>	
--	--	--	--	--	--

					- 6 удаагийн томилолтоор тоног төхөөрөмж ТХНС-д холболтын ажил гүйцэтгэсэн.		
2.	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр ашиглагдах бүх төрлийн мэдээллийг төрөлжүүлэн цуглуулж, сан үүсгэх, дүн шинжилгээ хийсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Уул уурхайн ашигт малтмал экспортолдог Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн, Булган, Бичигт, Ханги боомтуудад LPR буюу авто тээврийн хэрэгслийн улсын дугаар таних нийт 38ш камер суурилуулан, гаалийн телехяналтын нэгдсэн системд холбон тээврийн хэрэгслийн санг үүсгэн, цаашлаад дүн шинжилгээ хийх, зөвлөмж илгээн ажиллах, “Ухаалаг гарц”-ын системтэй холбох нөхцөл бололцоог ханган ажилласан.	- Гаалийн хяналт бүрдүүлэлттэй холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ГЕГ-ын удирдлага болон холбогдох чиг үүргийн нэгжийг мэдээллээр хангаж ажилласан байна. - Улсын хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн орсон гарсан бүртгэлийн сан, эрсдэлтэй зорчигчийн царай таних сан, зөрчилд холбогдсон барааны санд тус тус дүн шинжилгээ хийж, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавин, зөвлөмж илгээсэн байна.	Улсын хилээр нэвтрэх зорчигч тээврийн хэрэгсэлд эрсдэл тооцон зөвлөмж илгээн ажиллахдаа дараах үндсэн сангуудад дүн шинжилгээ хийн, үйл ажиллагаандаа ашигласан байна. Үүнд: Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн, Булган, Бичигт, Ханги, Алтанбулаг боомтуудад LPR буюу авто тээврийн хэрэгслийн улсын дугаар таних нийт 38 камер гаалийн телехяналтын нэгдсэн системд холбогдон үүссэн тээврийн хэрэгслийн санд дүн шинжилгээ хийн ажиллаж байна. Тайлант хугацаанд ЗҮГГ-т суурилуулсан дугаар таних камерт нийт 224,713 тээврийн хэрэгслийн улсын дугаар давтагдсан тоогоор, уншигдсан он сар өдөр, цагтайгаар бүртгэгдсэн байна. Телехяналтын камерт Шивээхүрэн боомтын амралтын өдрүүдэд 2 тээврийн хэрэгсэл гаалийн хяналт шалгалтад хамрагдахгүйгээр хил нэвтэрснийг олж илрүүлсэн ба тухайн 2 тээврийн хэрэгслийн улсын дугаарыг дугаар таних системийн бүртгэлийн сангаас тухайн өдрийн цаг минуттайгаар олж тогтоон ЗТГ-т шилжүүлж, чиг үүргийн дагуу мэдээ мэдээллээр ханган ажилласан. Ухаалаг гарцын www.smartgate.ecustoms.mn порталд хүлээн авч байгаа ухаалаг гарцаар нэвтэрсэн тээврийн хэрэгслийн мэдээлэлд мөн адил өдөр тутам дүн шинжилгээ хийж, эрсдэл тооцон ажилладаг. Тайлант хугацаанд ЗҮГГ-ын ухаалаг гарцын бүртгэлийн санд ЗҮ зорчигч тээврийн цогцолборт- 344,579, ЗҮ ачаа тээврийн цогцолборт- 100,084 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байгаа ба эрсдэл тооцон зөвлөмж	2024.01.01-2024.06.10	

					<p>илгээх бүрт эрсдэлтэй тээврийн хэрэгслийг тухайн санд нягтлан шалгаж ажилласан.</p> <p>Шуурхай хяналтын төвд царай таних 2 серверийг нэмэлтээр суурилуулж гаалийн нэгдсэн телехяналтын системтэй холбон ЗТГ болон ХБГ-аас ирүүлсэн эрсдэл бүхий зорчигчийн мэдээллүүдийг оруулан хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>ЗҮГГ-ын ачаа тээврийн цогцолборт суурилуулсан том оврын тээврийн хэрэгслийг шалгах "ИСБА" рентген тоног төхөөрөмж-1, УХШИГГ-н бичиг захидал болон ачааны рентген тоног төхөөрөмж-2, Боршоо боомтын импорт талын зорчигчийн болон ачааны рентген- 2 тус тус ТХНС-д холбосон. Рентген тоног төхөөрөмжийн мэдээлэл бодит цагаар телехяналтын нэгдсэн системд харагдах, мөн тухайн мэдээлэл бичлэг хэлбэрээр сан үүсгэгдэн хадгалагдаж байгаа ба тухай бүрт нь мэдээллийг зөвлөмж илгээхдээ ашиглаж байна.</p> <p>2024 оны 05 дугаар сарын байдлаар хүлээн авсан нийт гомдол мэдээлэлд, 4 шалгуурт, зөрчилд холбогдсон бараанд тус тус дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээ мэдээллээр хангаж ажилласан.</p>		
3.	Мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан онилгоо хийн,	Хэрэгжилт, хувиар	Таблю дата аналитик платформ дээр хөгжүүлж буй шалгуураар өндөр эрсдэлтэй гэж онилогдсон мэдүүлэгт телекамерын системийг ашиглан мэдээлэлд дүн	- Мэдээлэлд дүн шинжилгээ хийн, шалгуур үзүүлэлтээр эрсдэл тооцон, илгээсэн зөвлөмж, онилгооны үр дүнд илрүүлсэн зөрчилд нөхөн төлүүлсэн татварын болон торгуулийн дүн	<p>Шуурхай хяналын төв нь нэгжийн даргын баталсан хуваарийн дагуу ГУАБ, ГУБ нар хуваарилагдсан газар хороод, гаалийн хяналтын бүсэд CAIS-д хүлээн авсан бараа тээврийн хэрэгслийн их өгөгдөлд Tableau дата аналитик платформыг ашиглан шалгуур үзүүлэлтэд үндэслэн дүн шинжилгээ хийж, давхар телекамерын тусламжтайгаар телехяналт тавьж, эрсдэл тооцон, CAIS-ийн Онилгооны програмаас зөвлөмж илгээн ажилладаг. Тайлант хугацаанд Tableau дата платформд оруулсан 4</p>	2024.01.01-2024.06.10	

<p>зөвлөмж илгээсэн байдал</p>		<p>шинжилгээ хийж, эрсдэл тооцон, 34 мэдүүлэгт зөвлөмж илгээснээс гаальд мэдүүлсэн барааны нэр төрөл, тоо хэмжээ зөрүүтэй, бараа мэдүүлэх журам зөрчсөн 21 зөрчил илрүүлж, нөхөн төлүүлсэн татварын дүн: 212,059,199.09 төг, торгуулийн дүн: 108,029,599.5 төг төлүүлсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 118.15 хувиар өссөн үзүүлэлттэй ажилласан.</p>	<p>өмнөх оны мөн үеэс 5-аас дээш хувиар өссөн байна.</p> <p>- Оновчгүй зөвлөмжийн нийт онилгоонд эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс бууруулсан байна.</p>	<p>шалгуур үзүүлэлтүүдэд судалгаа хийн, их өгөгдлийг боловсруулах дараах ажлуудыг Tableau дээр хийсэн байна. Үүнд: Дараах 4 шалгуурт үндэслэн гарах дүн шинжилгээний мэдээг Tableau дээр нэг дор харагддаг байхаар шийдсэнээр, өгөгдлийн боловсруулалтын мэдээллийг түргэн хугацаанд харах, эрсдэл тооцоход илүү хурдан болгосон.</p> <ul style="list-style-type: none"> • Эрсдэлтэй гаалийн мэдүүлэг • Эрсдэлтэй бараа /зөрчилд холбогдсон барааны мэдээллийн санд хийсэн судалгаанд үндэслэн/ • Барааны жин • Бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа. <p>2023 онд зөрчилд холбогдсон иргэн, ААН-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн судалгааг хийн, давтамж өндөр байгаа нэрсийг шалгуураар оруулан, гаалийн мэдүүлэгт эрсдэл тооцож байна.</p> <p>CAIS-д мэдүүлсэн бараа тээврийн хэрэгслийн өгөгдлийг Табью дата аналитик платформ ашиглан, бодит цагаар боловсруулан сонгогдсон эрсдэлтэй гаалийн мэдүүлэгт Телехяналтын нэгдсэн систем болон рентген тоног төхөөрөмж, ухаалаг гарц, дугаар таних системд хүлээн авсан мэдээлэлд давхар дүн шинжилгээ хийн, эрсдэл тооцож, CAIS Онилгооны програмаар тайлант хугацаанд 60 зөвлөмжийг гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд илгээсэн байна. Үүнээс 47 буюу 78.33%-д нь татвараас зайлсхийсэн болон зайлсхийхийг завдсан, эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрлөөр улсын хил нэвтрүүлэх шаардлагатай хориглосон хязгаарласан барааг хууль бусаар хил нэвтрүүлэхийг завдсан зөрчлүүдийг илрүүлсэн байна. Зөвлөмжийн дагуу илрүүлсэн 47 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.21</p>	
--------------------------------	--	---	--	--	--

					<p>дүгээр зүйлийн 1.1, 1.2 заалтын дагуу арга хэмжээ авагдаж, 257.3 сая. төг татварыг нөхөн төлүүлж, 119.9 сая.төг торгууль ногдуулан төлүүлсэн.</p> <p>Оновчгүй зөвлөмжийн нийт онилгоонд эзлэх хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Барааны жин, Бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа, Эрсдэлтэй барааны шалгуур тус бүрт 100%, Эрсдэлтэй гаалийн мэдүүлэг шалгуурт 9.6%-иар тус тус бууруулсан. Оновчгүй зөвлөмжийн нийт онилгоонд эзлэх хувь үндсэндээ 16.54%-иар буурсан үзүүлэлттэй байна.</p>		
4.	Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд тавьсан хяналт, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн байдал, аюулгүй байдлыг хангахад хамтран ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>1. Тайлант хугацаанд ГУАБ, ГУБ нар хуваарилагдсан газар хороод, гаалийн хяналтын бүсэд телекамерын нэгдсэн систем болон таблю дата аналитик платформыг ашиглан хяналт тавьж, өндөр эрсдэлтэйд тооцсон гаалийн мэдүүлэгт дүн шинжилгээ хийн, CAIS гаалийн автоматжуулсан системээр нийт 34 мэдүүлгийн үе шатанд зөвлөмж илгээн, гаальд мэдүүлсэн барааны нэр төрөл, тоо хэмжээ зөрүүтэй 21 зөрчил илрүүлсэн нь өмнөх онтой</p>	<p>- Теле хяналтын нэгдсэн систем, ухаалаг гарц, рентген төхөөрөмжийг ашиглан гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд эрсдэл тооцож, илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үеэс 5-аас дээш хувиар өссөн байна.</p> <p>- Төрийн бусад байгууллагуудтай хамтран хууль сахиулах үйл ажиллагаанд теле хяналтын нэгдсэн системийг үр бүтээлтэй ашигласан байдал</p>	<p>Таблю дата аналитик платформ ашиглан, бодит цагаар боловсруулан сонгогдсон эрсдэлтэй гаалийн мэдүүлэгт Телехяналтын нэгдсэн систем болон рентген тоног төхөөрөмж, ухаалаг гарц, дугаар таних системд хүлээн авсан мэдээлэлд давхар дүн шинжилгээ хийн, эрсдэл тооцож CAIS-ийн онилгооны програмаар тайлант хугацаанд 60 зөвлөмжийг гаалийн хяналт шалгалт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд илгээснээс 47 буюу 78.33%-д нь татвараас зайлсхийсэн болон зайлсхийхийг завдсан, эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрлөөр улсын хил нэвтрүүлэх шаардлагатай хориглосон хязгаарласан барааг хууль бусаар хил нэвтрүүлэхийг завдсан зөрчлүүдийг илрүүлж, таслан зогсоосон байна. Тайлант хугацаанд илрүүлсэн зөрчлийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 124%-иар, илгээсэн нийт зөвлөмжид эзлэх зөрчил илрүүлэлтийн хувь нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.54%-иар тус тус өсч, гүйцэтгэлийг бүрэн хангаж ажилласан.</p> <p>Хууль сахиулах чиг үүргийн бусад төрийн байгууллагад хууль сахиулах үйл ажиллагаанд</p>	2024.01.01-2024.06.10	

			<p>харьцуулахад 50%-иар, илгээсэн зөвлөмжид эзлэх хувь 7.9%-иар тус тус өссөн үзүүлэлттэй ажилласан.</p> <p>2. 2023 оны 2 дугаар улиралд Цагдаа, Тагнуулын байгууллагатай хууль сахиулах үйл ажиллагаанд хамтран ажиллах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд 2023 оны 06 дугаар сард хамтарсан ажиллагааг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2023.04.11-ний өдөр ДоГГ-ын Хавирга боомтод гал түймэр гарсан. Тухайн цаг мөчид ТХНС-д холбогдсон телехяналтын камерын тусламжтайгаар хилийн боомтын барилга байгууламж, албан хаагчдын орон байрт түймэр ойртож буй талаар ГЕГ-ын удирдлагуудад шуурхай мэдээллэж ажилласан.</p>	<p>өмнөх оны мөн үеэс 3-аас дээш хувиар өссөн байна.</p> <p>- Теле камерыг ашиглан гаалийн байгууллагын барилга байгууламж, албан хаагчдын аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.</p>	<p>нотлох баримт бэхжүүлэх зорилгоор 2 удаагийн, ЗТГ дамжуулан 3 удаагийн бичлэгийг нотлох баримтжуулан хуулбарлаж хүргүүлсэн. Энэ нь өмнөх оны мөн үеэс 25%-иар өссөн байна.</p> <p>Телекамерийн хяналтаар Шивээхүрэн боомтоор 2 тээврийн хэрэгсэл гаалийн хяналт шалгалтад хамрагдахгүйгээр 2024 оны 03 дугаар сарын 10-ны өдөр хилийн бүсээр зорчсон нь Хилийн тухай хуулийн 17.2, ГЕГ-ын даргын 2019 оны А/275-р тушаалаар баталсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам"-ын 3.2 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байх тул шалгуулахаар ЗТГ-т шилжүүлсэн. 2024 оны 6 дугаар сард орсон их борооны үеэр гаалийн байгууллагын барилга байгууламж, албан хаагчдын аюулгүй байдлыг үер усны аюулаас сэргийлэх үүднээс болзошгүй боомт, хяналтын бүсүүдэд онцгойлон хяналт тавин ажилласан.</p>		
5.	Гаалийн байгууллагатай холбоотой	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	1. Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарт 2023.01.02-	- Харьяа гаалийн газар, хороодод ашиглагдаж буй	2024 оны 06 дугаар сарын 25-ний өдрийн байдлаар Гаалийн байгууллага нийт 4610 дуудлага, гомдол мэдээлэл хүлээн авснаас	2024.01.01-2024.06.10	

<p>гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлүүлсэн байдал</p>		<p>ноос 2023.06.15-ны өдрийг дуустал нийт 2597 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс: -гомдол, шүүмжлэлтэй холбоотой-78 -Зөрчлийн мэдээлэл-8 Асуулт лавлагаан-2511 байсан. Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-өөр дамжуулан гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт 141 гомдол, санал, хүсэлт хүлээн авсан (Гомдол - 120, Хүсэлт – 14, Санал – 6, Талархал-1).</p>	<p>санал, гомдол хүлээн авах дугааруудыг 1800-1281 тусгай дугаарт шилжүүлэн нэг цэгт төвлөрүүлж, сан үүсгэх нөхцөл бололцоог бүрдүүлсэн байна. - Гаалийн лавлах 1800-1281, Засгийн газрын гомдол мэдээлэл хүлээн авах 11-11 төвийн утсанд, Бүрдүүлэлтийн цахим нэгжид ирсэн гомдол мэдээллийг хүлээн авах, бүртгэх, холбогдох нэгжид шилжүүлэх, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох нэгжийн болон ГЕГ-ын удирдлагад тайлагнасан байна. - Иргэд аж ахуйн нэгжид гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол мэдээллийн</p>	<p>Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарт гомдол-73, зөрчлийн мэдээлэл-6, санал-7, хүсэлт-8, шүүмжлэл-1, асуулт лавлагаа-3584 буюу нийт 3673 дуудлага, ЗГ Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан гаалийн байгууллагатай холбоотой гомдол-133, санал-11, хүсэлт-6, шүүмжлэл-0, талархал-2 буюу нийт 152 дуудлага, Цахим бүрдүүлэлтийн төвд цахимаар гомдол-257, хүсэлт-528 тус тус бүртгэгдсэн байна.</p> <p>1800-1281-ийн үйлчилгээг сайжруулж Callcentre буюу "Дуудлагын төв" үйлчилгээг нэвтрүүлж, бүх ЗББНДБ болон харьяа ГГХ-ыг 1800-1281 тусгай дугаарт холбон, нэг цэгт төвлөрүүлсэн. 1800-1281-д хандсан дуудлага бүр автоматаар бүртгэгдэж, 3 сарын хугацаатайгаар дуудлага бүртгэл, ярианы бичлэгийн сан үүсгэн, тайлан гаргах, дүн шинжилгээ хийх боломжтой болгосон.</p> <p>Гаалийн байгууллагад ирсэн гомдол, санал, хүсэлт, зөрчлийн мэдээллийн шийдвэрлэлтийн явцын 7 хоног бүрийн мэдээг Цахим болон шуурхай хуралд, ГЕГ-ын дарга болон ЗТГ-ын даргад тайлагнаж, удирдлагыг мэдээ мэдээллээр хангаж ажилласан.</p> <p>Тайлант хугацаанд 2024 оны 05 дугаар сарын байдлаар гаалийн байгууллагад ирсэн нийт дуудлага, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийн, тайланг ЗУГ-т хүргүүлсэн.</p> <p>Иргэн, аж ахуйн нэгжид гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн тайланг улирал бүр ОНХА-д, Гаалийн лавлах 1800-1281-ээр хүлээн авсан</p>		
---	--	---	--	---	--	--

				<p>шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг Олон нийттэй харилцах нэгжтэй хамтран олон нийтэд мэдээлэх ажлыг улиралд 1 удаа зохион байгуулсан байна.</p> <p>- Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарыг ОНХ нэгжтэй хамтран иргэн хуулийн этгээдэд сурталчилан таниулах ажлыг зохион байгуулсан байна.</p>	<p>дуудлага, гомдол мэдээллийн сар бүрийн тайланг СДШХ-т тус тус хүргүүлэн ажилласан.</p> <p>ШХТ-өөс телехяналтын нэгдсэн системд бүрэн холбож, телехяналтыг хэрэгжүүлэн ил тод байдлыг ханган ажиллаж байгаа талаар, мөн Гаалийн лавлах 1800-1281 тусгай дугаарын зөвлөх үйлчилгээг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, гаалийн байгууллаас үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийг тус тус бэлтгэн 3 мин шторк ОНХА, АТГ-тай хамтран хийсэн. Шторк АТГ-ын цахим хуудаст байршсан.</p>		
6.	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>2023 оны эхний 11 сарын байдлаар Хяналтын нэгдсэн төвд ЗДАС программын Үүрэг даалгаврын хэсэгт 9 үүрэг даалгавар өгөгдсөн ба биелэлтийг цаг хугацаанд нь оруулан ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Онлайн хурлын даалгавар-2 -Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан-1 -Зөвлөмж- 4 -Албан даалгавар 2 биелэлтийг хангаж, 	<p>Удирдлагын шуурхай хуралдаан, Захиргааны зөвлөл болон Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Онлайн хурлаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажилласан байна. Харьяа гаалийн газар хороодод өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан, ЗДАСП-</p>	<p>ЗДАС-ын Үүрэг даалгаврын цэсэнд ЗУГ-аас 4 үүрэг даалгавар, ХШУДАГ-аас 2 зөвлөмж ирснийг хэрэгжилтийг ханган, биелэлтийг оруулсан.</p> <p>ГЕГ-ын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь хийж хэрэгжилтийг ханган, биелэлтийг танилцуулан ажилласан.</p>	2024.01.01-2024.06.10	

			тайлагнаж ажиллалаа.	Д үнэлж, дүгнэсэн байна.			
7.	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2023 оны нэгжийн үнэлгээ 4.5 байна.	Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг суурь түвшингээс бууруулахгүй байна.	Тайлант хугацаанд Хөдөлмөрийн дотоод журмын дагуу төвийн бүх албан хаагч ажлын өдрийн өглөө, орой бүр цаг бүртгэлийн царай таних төхөөрөмжид тогтмол бүртгүүлж, зайлшгүй шаардлагаар гадуур ажиллах, томилолтоор явах, өвчтэй, чөлөөтэй тохиолдолд СЕРР-д тухай бүр хүсэлтээ оруулан илгээж хэвшсэн. ГУАБ А. Эрхбаяр (2024.05.13-2024.07.01), Ш. Батболд (2024.05.13-2024.06.09) нар МУЗГ-аас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд томилолтоор ажиллаж байна. ГЕГ-ын даргын тушаалаар ГУБ Г. Бэрцэцэг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ШХТ-д томилогдон ажиллаж эхэлсэн. 2024 оны эхний улиралд нэгжийн ГУАБ, ГУБ нар 59 илүү цаг ажилласан ба илүү цагаар ажилласан шалтгаан, тайлбарыг гаргаж, Захиргааны удирдлагын газарт 2024.04.22-ны өдрийн 51 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн. Албан хаагчдын ажлын цаг ашиглалтын байдалд тогтмол хяналт тавьж ажилласан ба ГУБ болон ГУАБ нарын ажлын үзүүлэлтэд цаг ашиглалтыг дүгнэж, ТЖАХ-ын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд тусгаж дүгнэсэн.	2024.01.01- 2024.06.10	
Зорилт 2. “ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ”							
1.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2023 онд нэгжийн чиг үүрэгт хамааралтай бодлогын баримт бичиг тусгагдаагүй байна.	Бодлогын баримт, бичигт тусгагдсан нэгжийн чиг үүрэгт хамаарах арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж,	- Тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн сар бүрийн болон 2024 оны эхний хагас жилийн тайланг Хуулийн хэлтсээр дамжуулан Сангийн яаманд; - Гаалийн байгууллагын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг 2024.06.18-ны өдөр ЗУГ-т;	2024.01.01- 2024.06.10	

				<p>тухай бүр тайлагнасан байна.</p>	<p>- Гаалийн ерөнхий газрын 2024 оны эхний хагас жилийн "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний биелэлтийн тайланг 2024.06.12-ны өдөр ЗУГ-т;</p> <p>- Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаанд холбогдох хуулийн хэрэгжилтийн хагас жилийн биелэлтийг 2024.06.17-ны өдөр Хуулийн хэлтэст;</p> <p>- Гаалийн байгууллагын 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2024.06.19-ний өдөр ЗУГ-т;</p> <p>- Авилгатай тэмцэх газраас Гаалийн ерөнхий газарт ирүүлсэн зөвлөмжийн тайланг 2024.06.19-ний өдөр ЗУГ-т тус тус хүргүүлж ажилласан.</p>		
2.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	<p>Нэгжийн чиг үүргийн дагуу Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж, хэрэгжилтийг тайлагнаж ажилласан.</p> <p>Монгол улсын Ерөнхий сайдын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн №10 дугаартай албан даалгавар, Сангийн сайдын 2022_16 дугаартай "Гаалийн</p>	<p>Нэгжийн чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажилласан байна.</p>	<p>"Гаалийн лавлах 1281-ийн үйл ажиллагааны заавар"-ын шинэчлэн боловсруулсан төслийг 2024.06.14-ний ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн, хуралдааны 06/01 шийдвэрийн дагуу гишүүдийн саналыг тусган, ГЕГ-ын даргын 2024.06.27-ны өдрийн А/394 тушаалаар "Гаалийн байгууллагын тусгай дугаар ашиглах заавар" нэртэйгээр батлуулсан.</p> <p>Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган, хуулийн хэрэгжилтийн тайланг 2024.06.17-ны өдөр ХХ-т хүргүүлсэн.</p> <p>Сангийн яаманд хүргүүлэх тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр гарган ХХ-т хүргүүлсэн ба 2024.06.19-ний өдөр 2024 оны эхний хагас жилийн тайланг хүргүүлсэн.</p>	2024.01.01-2024.06.10	

			байгууллагын үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай" шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.				
3.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2023 онд энэ ажил төлөвлөгдөөгүй болно.	Нэгжийн эрсдэлийг таньж тогтоон сан үүсгэнэ.	Тус нэгжийн албан хаагч нар 2 удаагийн хурал хийж ГЕГ-ын даргын 2022.12.14-ны өдрийн А/342 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх" журмын 5.7.2-5.7.4 дэх хэсэгт заасны дагуу эрсдэлийн давтамж, үр дагаварын үржвэрээр эрсдэлийн матрицаа гаргаж, эрсдэлийн түвшинг тодорхойлсон. 8 чиглэлээр эрсдэлийг таньж тогтоон сан үүсгэн ажилласан.	2024.01.01-2024.06.10	
4.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй ажил	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн ГЕГ-ын даргын А/248 тоот тушаалаар "Хяналтын нэгдсэн төвийн үйл ажиллагааны заавар"-ыг хавсралт ёсоор батлуулсан. Тушаалыг ЗДАС программд байршуулан, тушаалтай танилцаж, хэрэгжүүлж ажиллахыг ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар хороодод Спаркар мэдэгдэж ажилласан.	Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухай бүр орж ажилласан байна. 2009 оны 169 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн лавлах 1281"-ийн үйл ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна.	ГЕГ-ын даргын 2009 оны 169 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн лавлах 1281-ийн үйл ажиллагааны заавар"-ыг шинэчлэн боловсруулж, төслийг ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр холбогдох материал, танилцуулгыг хүргүүлэн, 2024 оны 06-р сарын 14-ний 06/01 хуралдаанаар хэлэлцүүлж, 100% батлуулахаар дэмжигдэн, ГЕГ-ын даргын 2024.06.27-ны өдрийн А/394 тушаалаар батлагдсан. Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, ажлын хэсгийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: МУЗГ-с хэрэгжүүлж буй "Гаалийн шинэчлэл"-ийн хүрээнд Боршоо, Сүхбаатар, Алтанбулаг боомтод телехяналтын систем нийлүүлэх 2023 оны Б-15 дугаар гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах ГЕГ-ын даргын А/519 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ГУБ Ш. Батболд ажиллаж биелэлт хангасан. Бүрдүүлэлтийн цахим төвийн камержуулалтын тендерийн үнэлгээний хороонд дарга	2024.01.01-2024.06.10	

					<p>Ц.Хатанболд, ГУБ Б.Очтуяа нар ажиллаж, тендерийг зарласан үе шаттай байна.</p> <p>Гаалийн хяналт шалгалтын "УХААЛАГ ГАРЦ" иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах гэрээний хэрэгжилтийг хангах ГЕГ-ын даргын 2024 оны А/191 тушаалаар батлагдсан ажлын хэсэгт ГУАБ Д.Ганцолмон ажиллаж, Ханги боомтод суурилуулах цэгийг тодорхойлсон. Ухаалаг гарцтай холбоотойгоор 6 удаа томилолтоор ажилласан байна.</p> <p>2024 оны улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх шуурхай ажлын төлөвлөгөөний хүрээнд Ш.Батболд ЗҮГГ-т томилолтоор ажиллаж, ГХБийн ачааллыг судлан, рентген шалгасан дүрсийг ББ-т хавсаргах, гаалийн хяналт шалгалтын явцад бичлэг хийн баримтжуулах талаар заавар чиглэлийг өгсөн. Тус төлөвлөгөөний хүрээнд гаалийн хяналт бүрдүүлэлтэд дүн шинжилгээ хийх ажлын хэсэгт ГУБ Г.Бэрцэцэг биелэлтийг ханган ажиллаж байна. Нэгжийн албан хаагчид тайлант хугацаанд 4 ажлын хэсэгт орж ажиллан, цаг үеийн шинжтэй арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор 7 удаагийн томилолтоор ажилласан байна.</p>		
5.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй ажил	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2023 онд энэ ажил төлөвлөгдөөгүй болно.	Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гаалийн лавлах 1800-1281, ЗГ 11-11, Цахим бүрдүүлэлтийн төвд иргэд, олон нийтээс "Гаалийн байгууллагын үйл	Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гаалийн лавлах 1800-1281, ЗГ 11-11, Цахим бүрдүүлэлтийн төвд 2024 оны эхний 5 сард иргэд, олон нийтээс "Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд хийсэн дүн шинжилгээг, мөн төлөвлөгөөний биелэлтийн тайланг ЗУГ-т тус тус хүргүүлж, биелэлтийг бүрэн хангаж ажилласан.	2024.01.01-2024.06.10	

				ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд улирал тутам дүн шинжилгээ хийж, тайланг ЗУГ-т хүргүүлэн ажилласан байна.			
--	--	--	--	--	--	--	--


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Төрийн албаны тухай хуулийн дагуу богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ГЕГ, Дотоодын цэргийн штабаас хамтран 2023.05.11-12-ны өдрүүдэд зохион байгуулсан "Шуурхай удирдлага, зохицуулалтын дадлага, сургалт", Удирдлагын академи, Төрийн албаны сургуулийн "Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт" /2023-06-09. №А3831/,	Хууль эрх зүйн мэдлэг, мэдээллээ бататгаж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	2024 оны 04 дүгээр сарын 08-наас 10-ны өдрүүдэд Олон улсын валютын сангаас зохион байгуулсан "Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөн шалгах ажиллагааны дэвшилтэд арга техник" сургалтад хамрагдаж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой хууль эрхзүйн мэдлэгээ дээшлүүлсэн. 2024 оны 05 дугаар сард Засгийн газрын Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдаж, амжилттай дүүргэн АЗ сертификаттай төгссөн. 2024 оны 06 дугаар сард БНХАУ-д зохион байгуулсан Ухаалаг гарц, том оврын рентген төхөөрөмж, хяналтын системийн үйл ажиллагаатай танилцах сургалт арга хэмжээнд биечлэн оролцож, дэлхийн дэвшилтэт техник технологийг гаалийн хяналтад хэрхэн ашиглаж болох талаар туршлага судалсан.	2024.01.01 - 2024.06.10	

					Шинээр батлагдсан болон шинэчлэгдсэн хууль тогтоомжийг тухай бүрт судалж, хууль эрхзүйн мэдлэгээ бататгаж ажилласан байна.		
2.	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Англи хэл бие даан сурч, хэлний зохих түвшиний мэдлэгтэй болсон.	Англи хэлний мэдлэгийн түвшинг дээшлүүлсэн байна.	ГЕГ-ын дэргэдэх Сургалтын төвөөс 1 жилийн хугацаатайгаар зохион байгуулж байгаа "Англи хэлтэй албан хаагч" хөтөлбөрт хамрагдан, англи хэлний мэдлэгээ дээшлүүлж байна.	2024.01.01 - 2024.06.10	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Шуурхай хяналтын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



..... /Ц. Хатанболд/

2024 оны ⁰⁶ сарын ⁰⁷ өдөр

**ШУУРХАЙ ХЯНАЛТЫН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ ЦОГТСАЙХАН ОВОГТОЙ ХАТАНБОЛДЫН 2024 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Шуурхай хяналтын төв

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		60.4

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Төрийн албаны тухай хуулийн дагуу богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах		15
2.	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх		15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	13
2.	Удирдан зохион байгуулах	9
3.	Асуудал шийдвэрлэх	9
4.	Манлайлах	9
5.	Багаар ажиллах	11
6.	Харилцаа	14
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	11
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		11

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	60.4
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	11
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	86.4

	(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
<p align="center">Нийт оноо =</p> <p>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо</p>		

Үнэлгээ өгсөн:

Төсвийн шууд захирагч
Гаалийн ерөнхий газрын дарга



/Р. Отгонжаргал/

2024. 06. 19 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Нэгжийн дарга
Шуурхай хяналтын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

/Ц. Хатанболд/

2024. 06. 19 (огноо)